



## “МОНИНЖБАР” КОМПАНИЙН УДИРДЛАГАД

### Хараат бус аудиторын тайлан

Бид Аудитын тухай хуулийн 10 дугаар зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн холбогдох заалтуудыг үндэслэн “Монинжбар” ХК-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон Санхүүгийн байдлын тайлан, Орлогын дэлгэрэнгүй тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан буюу тайлангийн тодруулгуудаас бүрдсэн жилийн эцсийн Санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар “Монинжбар” ХК-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон бэлтгэсэн санхүүгийн тайлангууд нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС), Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн. АОУС-д заасан аудиторын хүлээх үүрэг, хариуцлагыг “Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг, хариуцлага” гэсэн хэсэгт тусгаж харуулав. Аудитын ажилд хамааралтай хараат бус байдлын болон ёс зүйн шаардлагуудыг бүрэн биелүүлж ажилласан. Бидний олж авсан баримт нотолгоонууд дээрх дүгнэлтийг гаргахад хангалттай, тохиромжтой гэж үзэж байна.

### Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх үүрэг, хариуцлага

Санхүүгийн тайлангаа СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан заавар журмын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг холбогдох стандарт, хуульд нийцүүлэн боловсруулан, тогтмол мөрдөж ажиллах нь тухайн байгууллагын удирдлагын үүрэг болно.

Мөн түүнчлэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хангах, хөрөнгийг янз бүрийн зальт ажиллагаанд өртүүлэхгүй байхаар дотоод хяналтын системийг бий болгох, байгууллагын үйл ажиллагааны болон нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурь, зарчмыг хангаж ажиллах нь байгууллагын удирдлагын хариуцлага юм.

## Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг, хариуцлага

Аудиторын гол зорилго нь үйлчлүүлэгчийн санхүүгийн тайлангууд нь алдаа эсвэл залилангийн улмаас материаллаг буруу илэрхийллээс ангид эсэхэд дүгнэлт өгөхөд оршино. Тодорхой дүгнэлтэд хүрэхийн тулд АОУС-д нийцүүлэн боловсруулсан горимын дагуу шалгалт хийж, хангалттай, тохиромжтой баримт нотолгоо цуглуулах нь аудиторын үүрэг юм.

Аудитын горимуудыг батлагдсан төлөвлөгөөний дагуу аудитор өөрийн шийдлээр сонгох ба ирүүлсэн алдаа, зөрчил нь материаллаг буюу байгууллагын удирдлага болон хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх эсэхэд дүн шинжилгээ хийж, түүнд тохирсон дүгнэлт өгнө.

Аудитын шалгалтаар байнга алдаа зөрчил илрэх ёстой гэсэн ойлголт байж болохгүй бөгөөд бидний илрүүлсэн алдаа, зөрчил материаллаг бус бол түүнийг арилгуулах талаар тодорхой зөвлөгөө өгч ажиллана.

Цаасан болон цахим хэлбэрээр бэлтгэсэн аудитын ажлын баримтууд нь тус компанийн өмч бөгөөд аудиторын тайлан, зөвлөмжийн хамт 10 жил хадгална.

ЗАХИРАЛ

Х.БАЯНБАЙ

Огноо: 2021-01-28

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,  
6-р хороо, Гео төвийн байр, 407, 408, 409 тоот.  
Утас: 976-11-462131, 976-91919758, 976-96969758.  
И-мэйл: akpar.audit@gmail.com